



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2015.07.03 № 4-1/4198  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧ, АЙМАГ,  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
НАРТ

Монгол Улсын 2016-2018 оны  
төсвийн төсөл бэлтгэх тухай

Улсын Их Хурлын 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хууль батлагдсан. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн боловсруулсан "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2016 оны төсвийн хязгаар"-ыг Засгийн газрын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар баталлаа.

Төсвийн тухай хуулийн 8.3.4-д заасны дагуу батлагдсан төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт хавсралтаар хүргүүлж байна. Мөн цахим хэлбэрээр Төсвийн ил тод байдлын [www.iltod.gov.mn](http://www.iltod.gov.mn) болон Сангийн яамны [www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn) цахим хуудаснаас татаж авах боломжтой.

Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасны дагуу 2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөллийг "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2016 оны төсвийн хязгаар"-т багтаан, төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу боловсруулан 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт: №1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2016-2018 оны төсвийн төслийг бэлтгэх удирдамж

Хавсралт: №2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2016 оны төсвийн хязгаар

САЙД



Ж.ЭРДЭНЭБАТ

003076